



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



“АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛ СУДАЛГАА”-НЫ 2018-2021 ОНЫ ҮР ДҮН

Улаанбаатар хот
2022 он



АГУУЛГА

БҮЛЭГ I. УДИРТГАЛ

- 1.1. Ардчилсан засаглал судалгааг явуулах шаардлага, үндэслэл
- 1.2. Судалгааны зорилго, ач холбогдол
- 1.3. Судалгааны арга зүй

БҮЛЭГ II. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

- 2.1. Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээ
- 2.2. Төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээ
- 2.3. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн үнэлгээ

ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ, улсын дунджаар

1.1 Ардчилсан засаглал судалгааг явуулах шаардлага, үндэслэл

Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 13 дугаар тогтоолд Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хянах үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэх, хяналт тавих, төрөлжсөн болон тусгайлсан мэдээллийн санг улсын хэмжээнд бий болгохыг Засгийн газар, Үндэсний статистикийн хороо, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисст тухайн үед үүрэг болгосон.

Мянганы хөгжлийн зорилтын 9 дүгээр зорилгын 3 шалгуур үзүүлэлт нь олон нийтийн үнэлгээний үзүүлэлт бөгөөд уг үзүүлэлтүүдийг олон улсын туршлага, санаачилгыг харгалзан Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ноос тогтмол зохион байгуулдаг "Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа"-ны хавсралт (модуль) судалгаагаар цуглуулахаар ҮСХ-ны даргын 2008 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 10/100 тоот тушаалаар судалгааны үзэл баримтлалыг баталсан.

"Ардчилсан засаглал судалгаа"-ны асуулгыг 2018 онд "Тогтвортой хөгжлийн зорилт"-ын шалгуур үзүүлэлтүүдээр баяжуулан шинэчилж, ҮСХ-ны даргын 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/98 тоот тушаалаар батлуулан мэдээлэл цуглуулалтад ашиглаж байна.

1.2 Судалгааны зорилго

Судалгааны үндсэн зорилго нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын "Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх" 9 дэх зорилгын шалгуур үзүүлэлтүүд, Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд дэвшүүлсэн "Чанартай боловсролыг дэмжих" 4 дүгээр зорилго, "Жендерийн эрх тэгш байдлыг хангах" 5 дугаар зорилго, "Энх тайван, шударга ёсыг цогцлоох" 16 дугаар зорилго, "Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх" 17 дугаар зорилгуудын хэрэгжилтийг үнэлэх зарим шалгуур үзүүлэлтүүдийг улс, бүс нутгийн түвшинд тодорхойлоход чиглэгдсэн.

1.3 Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны судлагдах нэгж нь ҮСХ-ноос сар бүр тогтмол явуулж байгаа "Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа"-нд хамрагдсан өрхийн 15, түүнээс дээш насны эрэгтэй нэг, эмэгтэй нэг гишүүн байна.

Судалгааны түүвэрлэлт нь "Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа"-ны дэд түүвэрлэлт бөгөөд түүврийн хэмжээ нь 2552 өрх байна. Түүвэрлэлтийг хийхдээ эхний шатанд ӨНЭЗС-нд сонгогдсон өрхүүдээс 2552 өрхийг түүвэрлэн сонгосон. Хоёр дахь шатанд тухайн өрхөд амьдарч буй 15, түүнээс дээш насны өрхийн гишүүдийн жагсаалтаас санамсаргүй тооны Кишийн хүснэгтийн аргыг ашиглан судалгаанд хамрагдах хүмүүсийг сонгосон.


БҮЛЭГ II. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

“Ардчилсан засаглал” судалгааг 2008 оны III улирлаас эхлэн явуулж буй бөгөөд энэ удаад 2018-2021 оны үр дүнг харьцуулан танилцуулж байна. Судалгаанд 2021 онд 15 ба түүнээс дээш насны 3545 хүн хамрагдсанаас 48.0 хувь нь эрэгтэй, 52.0 хувь нь эмэгтэй байна.

2.1 Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээ

Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө нь хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, санхүү, эдийн засгийн хувьд хараат бус байдал хангагдсан эсэхээр илэрхийлэгдэнэ. Энэхүү хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээг 0-100 оноонд шилжүүлэн Зураг 2.1-д харууллаа. Оноо их байх нь иргэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг, оноо бага байх нь хараат байдаг гэж үздэгийг илэрхийлнэ.

ЗУРАГ 2.1. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГЭЭС ХАРААТ БУС БАЙДАЛД ӨГСӨН ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ, оноогоор, 2018-2021 он




Эх үүсвэр: АЗС 2018-2021

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төрөөс хараат бус байдаг гэдэгт итгэх иргэд буурчээ. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төрөөс хараат бус байдаг гэдэгт иргэдийн өгсөн оноо 2021 онд 23 болж 2018 оноос өөрчлөлтгүй, 2020 оноос 3 оноогоор буурсан байна. Эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг гэдэгт 2021 онд 2018 оноос 1 оноогоор өссөн, 2020 оноос 4 оноогоор буурчээ.

Нийт иргэдийн 33.6 хувь хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төрөөс хараат бус гэдэгтэй санал нийлдэггүй гэж үзсэн байхад 10.8 хувь санал нийлдэг гэж 2020 онд хариулж байжээ. Харин 2021 онд нийлдэг иргэдийн хувь 10.9 хувь буюу өмнөх оноос өөрчлөлтгүй байгаа ч санал нийлдэггүй иргэдийн хувь 38.7 хувь болж өмнөх оноос 5.1 нэгж хувиар өссөн буюу сөрөг хандлага нэмэгджээ. Нийт иргэдийн 24.4 хувь нь хэвлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг эсэхийг мэдэхгүй гэж хариулжээ (Зураг 2.2).


ЗУРАГ 2.2. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГЭЭС ХАРААТ БУС БАЙДЛЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: АЗС 2020, 2021

Хэвлэл, мэдээллийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 0-100 оноонд шилжүүлэн Зураг 2.3-т харууллаа. Иргэдийн өгсөн үнэлгээг 2018 оныг 2021 онтой харьцуулж үзэхэд, үндэсний олон нийтийн телевизэд өгсөн үнэлгээ 69-86, үндэсний радиод өгсөн үнэлгээ 50-73, хувийн телевизэд өгсөн үнэлгээ 66-72 болж өссөн бол орон нутгийн телевизэд өгсөн үнэлгээ 87-75, өдөр тутмын хэвлэлд өгсөн үнэлгээ 73-59, FM радиод өгсөн үнэлгээ 55-54 оноо болж тус тус буурсан байна (Зураг 2.3).

ЗУРАГ 2.3. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ИТГЭЛ ХҮЛЭЭЛГЭЖ БАЙГАА ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ, оноогоор, 2018-2021 он



Эх үүсвэр: АЗС 2018-2021

2.2 Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээ


Төрийн захиргааны дээд байгууллагууд, түүний дотор хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн өгсөн хариулт нь төр, засагтаа хэр зэрэг итгэл хүлээлгэж буйг илэрхийлэх үзүүлэлт юм. Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээг 0-100 оноонд шилжүүлэн Зураг 2.4-т харууллаа.





Төрийн эрх барих дээд байгууллагуудад өгсөн иргэдийн үнэлгээг харвал, Ерөнхийлөгчид өгсөн үнэлгээ 2018-2021 онд 44-59, Улсын Их Хуралд өгсөн үнэлгээ 13-42, Засгийн газарт өгсөн үнэлгээ 32-56 болж нэмэгджээ.

Шүүх засаглалын байгууллагуудад өгсөн иргэдийн үнэлгээг 2018-2021 оноор авч үзэхэд, Дээд шүүхэд өгсөн иргэдийн үнэлгээ 43-50, Нийслэл/аймгийн шүүхэд өгсөн үнэлгээ 45-50, Дүүрэг/сум дундын шүүхэд өгсөн үнэлгээ 49-53, Шүүхийн шийдвэр биелүүлэх газарт өгсөн үнэлгээ 49-60 болж өссөн хандлагатай байна.

Төрийн үйлчилгээний бусад байгууллагуудад өгсөн иргэдийн үнэлгээг 2018-2021 оноор харвал, Хэв журмын цагдаагийн албанд өгсөн үнэлгээ 83-83, Аудитын газар өгсөн үнэлгээ 73-73 өөрчлөлтгүй байгаа бол Эрүүгийн цагдаагийн албанд өгсөн үнэлгээ 77-80, нийгмийн халамжийн байгууллагад өгсөн үнэлгээ 85-87, төрийн өмчийн сургууль, цэцэрлэгүүдэд өгсөн үнэлгээ 87-92, төрийн өмчит эмнэлэгт өгсөн үнэлгээ 73-84 болж өссөн байна. Харин Замын цагдаагийн албанд өгсөн үнэлгээ 84-83, Галын байгууллагад өгсөн үнэлгээ 61-51, Татварын албанд өгсөн үнэлгээ 78-76, нийгмийн даатгалын байгууллагад өгсөн үнэлгээ 87-84 болж буурчээ.

ЗУРАГ 2.4. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ӨГСӨН ҮНЭЛГЭЭ, оноогоор, 2018-2021 он






Эх үүсвэр: АЗС 2018-2021

Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газарт итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг дүнд эзлэх хувиар нь гаргаж харууллаа.

Ерөнхийлөгчид итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2018-2021 оноор авч үзэхэд, ерөнхийлөгчид итгэдэггүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2018 онд 35.3, 2019 онд 29.0, 2020 онд 18.8 хувь байсан бол 2021 онд 27.2 хувь болж 2018 оны 8.1 нэгж хувиар буурч, өмнөх оноос 8.4 нэгж хувиар өссөн байна. Итгэдэг гэж хариулсан иргэдийн хувь 2018 онд 18.1, 2019 онд 23.0, 2020 онд 35.2 хувь байсан бол 2021 онд 29.3 хувь болж 2018 оноос 11.2 нэгж хувиар өсөж, өмнөх оноос 5.9 нэгж хувиар буурсан байна. Мэдэхгүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2018 онд 7.8, 2019 онд 6.7, 2020 онд 3.8, 2021 онд 3.1 хувьтай байна (Зураг 2.5).


ЗУРАГ 2.5. ЕРӨНХИЙЛӨГЧИД ИТГЭЛ ХҮЛЭЭЛГЭЖ БАЙГАА ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: АЗС 2018-2021

Улсын Их Хуралд итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2018-2021 оноор авч үзэхэд, итгэдэггүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2018 онд 58.5, 2019 онд 51.1, 2020 онд 34.3 хувь байсан бол 2021 онд 35.6 хувь болж 2018 оноос 22.9 нэгж хувиар буурч, өмнөх оноос 1.3 нэгж хувиар өссөн байна. Дунд зэрэг итгэдэг гэж хариулсан иргэдийнх 2018 онд 28.1, 2019 онд 34.6, 2020 онд 44.8 хувь байсан бол 2021 онд 42.6 хувь болж 2018 оноос 14.5 нэгж хувиар өсөж өмнөх оноос 2.2 нэгж хувиар буурчээ. Итгэдэг гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2018 онд 6.5, 2019 онд 9.0, 2020 онд 16.4, 2021 онд 19.1 хувь болж өсөх хандлагатай байна (Зураг 2.6).


ЗУРАГ 2.6. УЛСЫН ИХ ХУРАЛД ИТГЭЛ ХҮЛЭЭЛГЭЖ БАЙГАА ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: АЗС 2018-2021

Засгийн газарт итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2018-2021 оноор авч үзэхэд, итгэдэггүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2018 онд 50.0, 2019 онд 40.8, 2020 онд 22.6 хувь байсан бол 2021 онд 30.8 хувь болж 2018 оноос 19.2 нэгж хувиар буурч, өмнөх оноос 8.2 нэгж хувиар өссөн байна. Дунд зэрэг гэж хариулсан иргэдийнх 2018 онд 33.2, 2019 онд 36.9, 2020 онд 43.5 хувь байсан бол 2021 онд 41.1 хувь болж 2018 оноос 7.9 нэгж хувиар өсөж, өмнөх оноос 2.4 нэгж хувиар буурчээ. Итгэдэг гэж хариулсан иргэдийнх 2018 онд 9.5, 2019 онд 16.1, 2020 онд 29.5 хувь байсан бол 2021 онд 25.6 хувь болж өмнөх оноос 3.9 нэгж хувиар буурсан байна. Мэдэхгүй гэж хариулсан иргэдийнх 2018 онд 7.3, 2019 онд 6.1, 2020 онд 4.5, 2021 онд 2.6 хувь байна (Зураг 2.7).

ЗУРАГ 2.7. ЗАСГИЙН ГАЗАРТ ИТГЭЛ ХҮЛЭЭЛГЭЖ БАЙГАА ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: АЗС 2018-2021

2.3 Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн үнэлгээ

Судалгаанд оролцсон иргэдээс сүүлийн 12 сард төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагаас үйлчилгээ авсан эсэхийг асууж, “Тийм” гэж хариулсан бол тухайн иргэдээс үйлчилгээ авах үед авлига ажиглагдсан эсэхийг тодруулж асуусан (Зураг 2.8). Уг асуултыг асуухдаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагаас үйлчилгээ авах тохиолдол бүрээр нэр зааж асуусан бөгөөд авлига ажиглагдсан гэж түлхүү хариулсан үйлчилгээний төрлөөр үр дүнг харууллаа.

ЗУРАГ 2.8. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭНД АВЛИГА АЖИГЛАГДСАН ГЭЖ ХАРИУЛСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



Эх үүсвэр: АЗС 2018-2021

Сүүлийн 12 сард эмнэлгийн үйлчилгээ авахад авлига ажиглагдсан гэж хариулсан иргэдийн эзлэх 2018 онд 3.1, 2019 онд 2.6, 2020 онд 2.9 хувь байсан бол 2021 онд 1.6 хувь болж 2018 оноос 1.5 нэгж хувь, 2020 оноос 1.3 нэгж хувиар буурсан эерэг хандлага ажиглагджээ. Төрийн байгууллагад автын үзлэг, оношилгоо, дугаар авахтай холбоотой асуудлыг шийдэх үед авлига ажиглагдсан гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2018 онд 1.3, 2019 онд 0.6, 2020 онд 1.1 хувь, 2021 онд 0.8 хувь, хүүхэд сургууль, цэцэрлэгт оруулах үед авлига ажиглагдсан гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2018-2019 онд 2.7, 2020 онд 1.8 хувьтай байсан бол 2021 онд 0.5 хувь болж буурах хандлага ажиглагдсан байна.

НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР
ӨРХӨД СУУРИЛСАН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС
----- оОо -----

ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 1. ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ, улсын дунджаар

Үзүүлэлт	Үнэлгээ			
	2018	2019	2020	2021
Ерөнхийлөгч	43.6	57.0	74.4	59.4
УИХ	12.6	20.2	38.4	41.9
Засгийн газар	21.9	41.0	68.6	56.2
Улс төрийн намууд	10.3	14.7	17.3	23.3
Нийслэл/ аймгийн ИТХ	34.5	45.7	52.8	52.4
Дүүрэг/сумын ИТХ	43.8	52.6	60.0	62.0
Хороо/ багийн Иргэдийн Нийтийн Хурал	54.2	61.9	71.1	66.0
Нийслэл/ аймгийн Засаг дарга	50.9	59.2	70.4	67.4
Дүүрэг/ сумын Засаг дарга	57.6	62.9	70.5	70.3
Хороо/ багийн Засаг дарга	66.1	70.2	77.9	73.2
Дээд шүүх	42.9	39.0	46.8	50.4
Нийслэл/ аймгийн шүүх	44.9	44.5	50.3	49.9
Дүүрэг/сум дундын шүүх	48.5	47.9	54.7	53.1
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар	49.2	51.1	61.0	59.9
Замын цагдаа	84.4	83.4	85.1	82.9
Эрүүгийн цагдаа	77.3	76.9	81.9	80.3
Хэв журмын цагдаа	82.8	79.8	85.6	82.9
Авлигатай тэмцэх газар	32.0	34.2	44.4	43.9
Мэргэжлийн хяналтын газар	54.8	55.6	59.9	61.1
Аудитын газар	73.0	71.8	78.3	73.4
Гаалийн байгууллагууд	61.3	55.5	65.0	51.4
Газрын албад	50.9	50.1	52.4	51.4
Татварын байгууллагууд	78.3	77.5	81.1	76.2
Нийгмийн даатгалын байгууллагууд	87.4	87.3	89.1	83.6
Нийгмийн халамжийн байгууллагууд	85.0	85.1	91.1	86.8
Улсын сургууль	87.0	88.6	93.1	92.1
Улсын эмнэлэг	72.8	75.7	85.5	84.3

Тайлбар: Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээг 0-100 оноонд шилжүүлэн тооцсон